

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ванчигийн Лувсандорж	Дугаар	L029
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Сонгинохайрхан дүүрэг
Төрсөн газар	Архангай аймгийн Өлзийт сум	Төрсөн он	1919
Ажил мэргэжил	Тэтгэвэрт		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Өөлд бэйсийн хүрээ	Сүм хийдийн дугаар	APӨЗ 070
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2008 оны 1-р сарын 22	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Архангай аймгийн Өлзийт сумын Өөлд бэйсийн хүрээ

Өлзийтийн хошуу хийд уг нь нэлээд их үдсэн. 2, 3 зөөсөн юм байна лээ. Эхлээд Рашаантад, дараа нь Бодонтод, гурав дахь дээрээ тэр байгаа газраа ирсэн юм байгаа юм. Өөлд бэйсийн хүрээ Хөшөөтийн дэнжид байсан. Тахилгатай уул нэлээд. Янсан ядмыг тахихад нэлээд юм болно. Хоол унд элбэг дэлбэг байдаг байсан. Үхэр сэтэрлэнэ. Намар л тахидаг байсан. Түвдэнгийн хар шарыг сэтэрлэсэн гээд гар хүрээ гэдэг л байсан.

Манайх Сайн ноён хан аймгийн Өөлд бэйсийн хошуу. Миний үед хошуу ноён гэж байгаагүй. Хошуу ноёны хүү Бадамгарав гэж надаас хоёр гурав ах хүн байсан. Бадамгаравыг хүүхэд байхад нь Хүрээнд аваачиж ноёны ёс, ямбыг нь хийсэн юм гэсэн. Ноён суух байсан хүн л гэдэг байсан. Эцэг нь Сандаг гэж байсан. Сандагийн аав Дагдан бэйс гэж байсан юм гэнэ лээ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Манай хуучин Ганжуур үзүүр энэ тэр нь мөлийчихсэн байгаа юм. Эхлээд тэмээгээр ачаад нүүж яваад дараа нь Ганжуураар нутаг хошуугаа эргэж байсан. Алтан Зуу, Алтан Ганжуур гэж байгаа. Төвдөөс л барыг нь олж ирсэн байх. Олон боть байсан. Хуучин тэр хожгор болчихсон Ганжуураас хуулаад алт, эрдэнийн зүйл ашиглан гараар бичүүлсэн. Шатаая гэхэд шатахгүй байсан. Их хүнд, гараар хулсан үзгээр, их зузаан хар цаасан дээр бичсэн байсан. Би тэр Ганжуурыг барьж гүйлгэн уншиж байсан юм.

Би анх 8 настайдаа айлд өргөгдөөд тэнд очоод 1938 онд хүрээ хаагдтал байсан. Хооронд нь хөдөө ирэн очин байсан. Аавын дүү гурван хүн байсан. Жамсран, Жигжид, Мял гэж. Жамсран нь эмч маарамба, Жигжид нь чойр цанидын лам, Мял нь зурхай оролддог байсан. Жамсран, Жигжид хоёр нь Богдын хүрээнд байсан.

Өлзийтийн хошуу хийд том, жижиг нийлсэн 8 сүмтэй байсан. Цогчэн, Жүд, Манла, Янсан Ядам, Чойр, Зуугийн дуган, Цамын дуган, Чойжоо шүтээний дуган гэж байсан. Цагийн хурал хурна. Зуны адаг сарын 15-нд эхлээд хурна. Тэнд л хүүхэд томчууд нийлээд 500 хүрдэг байсан байх. Тэр үед Цогчэндээ хураад багтахгүй, Жүдэд тасарч хурдаг байсан юм. Хийдийн нэр Өөлд бэйсийн хүрээ л гэдэг байсан. Хүрээ дэгтэй хийд байсан. Баруун хүрээг их дууриана.

Цорж ламын хийд гэж тусдаа дуган байсан. Гачэн тусдаа жастай, Оромбо тустай хийдтэй байсан.

Чин цорж гэж нэг их лут хүн дуулдаж байсан. Төвд урдүүр явж явж алга болчихоод ирсэн. Тэр хүнийг нас барахаар нь Цагаан толгойн энгэрт бунхалсан. Оромбо гэгээний дүр тодорлоо гэсэн. Дашдоржоос хойш. Нэг жаахан хүүхэд. Тэр дүр нь мөн юм гэсэн. Удалгүй үхсэн.

Хийдийн миндагтангууд нь Хошуу хийдийн хамба лам Гачэн. Цорж лам нь нэг өвгөн лам байсан. Манайхан нутаг хошуугаараа цорж лам гэдэг байсан. Тусгай дугантай байсан. Унзад бол байсгээд л солигдоно. Магсар унзад гэж байсан. Сүүлийн үед нь Гомбо гэж залуу хүн байсан. Их сайхан дуутай. Гэсгүй нь Жамц гэж байсан. Сүүлдээ алба хийх хүнгүй болсон. Бариа тавиа, алба татвараас болоод. Жасын татварыг миндагтангуудаас нэхнэ. Жүдийн шунлайв Содном гэж байсан. Унзад нь Базар. Чойрын шунлайв Содном гэж байсан.

Хийдийн сахиус нь Лхам, гол шүтээн нь Зуу байсан.

Ядам нь Янсан ядам. Ноёны шүтээн нь Далх бурхан байсан.

Цэрэгт явах хүн Далх тахиулдаг байсан. Цэрэгт яваад хүүхэд чимээгүй болчихлоо. Далх тахиульа гэж ар гэрийнхэн нь ирдэг байсан. Чойр нь Гомбо сахиустай байсан.

Би Цогчэн, Жүд хоёрт хурж байсан. Манай зиндаа 20 гаруй хүүхэдтэй байсан. Жорвон нь Намсрайн Чойжил гэдэг хүүхэд байсан. Жүдэд ойр зуурын уншлага л уншиж байсан. Дарь эх, маань гээд дандаа цээжилнэ. Сарын дүйчэн хурлууд Баруун хүрээтэй адилхан байсан. Цагаан сарын шинийн нэгнээс хойш Домчид хурна. Хаврын эхэн сард ерөөл хурна. Алтан Зуугийн мөргөл тавина. Хаврын эхэн сарын 15-нд мөргөл гэж Алтан Зууг гаргана. Жилд хоёр удаа гаргана. Алтан Зуугийн мөргөл тавьсны дараа жижиг наадам хийнэ. Багачуудыг уралдуулна. Барилдуулна. Тэр нь тухайн үед удирдаж байсан хүнээсээ хамаараад хийвэл хийнэ. Хийхгүй бол хийхгүй тардаг байсан. Хайлан хийнэ. Зуны адаг сарын 15-нд эхлээд 45 хоног үргэлжилнэ. Хийдээс салдаггүй

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хэдэн гэлэн нар байсан. Цам гарна. Нэлээд олон юм гарна. Нийлээд гарахаараа бөөн л ажил болдог байсан. Баруун хүрээтэй адил. Зуны адаг сарын 15-нд Майдар эргэнэ. Нүгнээ сахих чинь айл айлынх. 3, 4 ламыг гэртээ аваачаад нүгнээ сахиулна. Дараа нь найр шиг юм хийгээд тарна. Сүүлдээ жижиг жижиг хурал энд тэндгүй гараад энд тэндгүй хурал ном болоод. Том лам нар шашин доройтох нь гэж хэлж байсан юм.

Чойртоо гэвш, гавж болно. Манбад маарамба болохгүй. Өөр газар очиж болдог байсан. Төвд лам байдаг байсан. Гачэнтэй хамт хэсэг хүмүүс ирээд баригдахад нь хамт баригдсан.

Манай хийдтэй ойролцоо баруун талдаа Луу гүний хүрээ, урдаа Шанхын хүрээ байсан. Оромбо гэгээний хүрээ Тамирын Улаан хошууны тэнд байсан. Оромбо гэгээний хүрээ манай хүрээнээс бага. Оромбо гэгээн өөрөө тэнд залагдаж байсан. Авгай хүүхэдтэй, зарцтай, малтай байсан. Оромбо гэгээнийг Дашдорж гэдэг байсан. Миний багын нэр Дашдорж. Тэгсэн Гэгээнтэй адилхан нэр гээд Даадаа гэж дуудах болсон. Тэр нь явсаар Доодоо гэдэг болсон. Би хар болсны дараа сувилагч болсон. Өлзийтийн эмнэлэгт ажиллаж байсан. Тэр үедээ Доодоо доктор гэж дуудуулж явлаа.

Дуганууд нь тус тусдаа жастай байсан. Хамгийн том жас нь Зүүгийн жас байсан. Жүдийн жас, Ядамын жас гээд байсан. Малтай байсан. Миний аав ээж хоёр жасын хонь, ганц нэг үнээг хариулж сааль сүүг нь авдаг байсан. Жасын ламыг тоолдог байсан. Гэсгүй, үнзад нар л энэ ажлыг хариуцдаг байсан байх. Би дотроо хүрээгээ эхэндээ их дэг журамтай, багш нь багш шиг, шавь нь шавь шиг байгаад сүүлдээ задгайраад муудаад ирж гэж боддог.

Хүрээнд лам нар хаанаас ч ирж сууж болно. Ер нь Өөлд бэйсийн хошууны лам нар сууж байсан. Дуганууд нь хятад маягийн одоо энэ Гандангийн дугантай адилхан дугантай байсан. Модон дуган ганцхан. Сүүлд барьсан Чойр дуган байсан. Бусад нь тоосгон дуганууд байсан.

Лам нар нь аймаглаж суудаггүй байсан. Зиндаагаараа байсан байх. Хүрээгээ тойроод л сууна. Хийдэд зоч, лүйжинч нар байгаагүй. Сүүлд хэсэг улс нийлээд сайн дураараа явж байсан. Хүмүүс их ам муутай байдаг байсан.

Хүрээ 1937, 1938 оны үед хаагдсан. Лам нар нь хөдөө гараад амины хашаа байшин хүртэл эзгүйрээд балгас болсон. Дуган сүмийг нь шууд нураагаагүй. Зүггүй банди нар чулуу уралдуулж шидэж тоглоод нэг мэдэхэд эвдэрч сүйдсэн байсан. Томоохон бурханыг нь ачаад явчихсан. Уул, хад, гол, жалга судгаар тарсан жижиг сажиг бурхан, тахил, цөгц энэ тэр юм энд тэндгүй байсан. Тэгээд л замхарсан. Ном судрыг бүгдийг шатаасан. Ном судруудыг том нүх ухаж байгаад хийж шатаасан. Хүүхэд байсан болохоор гүйгээд ир гүйгээд ир л гэж байсан. Баринтагтай судруудыг хэчнээн хутгаад ч шатдаггүй байсан. Нүх рүү хийчихээд хутгаад л байна. Хутгаад л байна.

Би хар болоод Өлзийтэд анхны эмнэлэгт ажиллаж байсан. Хамуу, махуу тэгээд арьс өнгөний өвчин их байсан. Тэр үеийн эмнэлэг гэдэг чинь “Сэрэлт” кино. Яг тэрэн дээр гардаг шиг байсан. Цэрэгт явах сонирхолтой болсон. Өвчтэй хүмүүсээс залхаад тэр. Ажлаас гаргадаггүй. Тэгээд нэг болзолтой ажилласан. Эмнэлгээ сайн болгож, сайн ажиллавал цэрэгт явуулна гэсэн. Сайн ч ажиллаа. Тэгээд цэрэгт 1942 онд явлаа. Сүхбаатар

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

аймгийн Байшинтын заставт. Тэндээ ч нэр сайтай байлаа. Тэгсэн хоёр гурван хүнийг хот руу шилжүүллээ. Бараг л нутаг заагдаж. Том лам нартай хамт байсан энэ тэр гээд. Жамсран, Жигжид хоёрыг буудаж хороосон. Нэг нь 10 жилийн ялаа өнгөрөөгөөд барилга дээр ажиллаж байхдаа унаж бэртээд тэгж байгаад нас барсан юм. Хотод ирээд Цэргийн төв клубт аж ахуйд ажилласан. Тэр үед халзан Лувсангомбо, Сэвжид, орос Гомбо гэсэн бүжигчид байсан. Тэндээсээ цэргээс халагдсан. Тэгээд хууль шүүхийн салбарт шүүгч, прокуроор ажилласаар тэтгэвэрт гарсан.

Шашин ном сэргэхэд эргэж лам болоогүй. Номоо бараг мартсан байна лээ.